



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Төрийн үйлчилгээний албан тушаалын
ажлын байрны тодорхойлолт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.17, 19.2.4 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/177 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мэдээллийн технологийн хэлтсийн кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг хавсралтад дурдсанаар баталсугай.

2.Ажлын байрны тодорхойлолтыг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Д.Мөнхбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Н.УУГАНБАЯР



172200936

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Кибер аюулгүй байдлын тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

22 10 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

22 08 30

Байгууллагын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Нэгжийн нэр:

Мэдээллийн технологийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Кибер аюулгүй байдал хариуцсан
ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээ, ТҮ-8

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа дэнж, Гадаадын
иргэн, харьяатын газрын төв байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, аюулгүй байдлыг үнэлэх, үүсэж болох эрсдэлийг тооцох, кибер орчин дахь мэдээллийн нууцлалын хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, эрхэлсэн ажлын хүрээнд удирдлагыг шуурхай мэдээллээр хангах.

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах, хамгаалах ажлыг зохион байгуулах;
2. Сервер, компьютер, сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, нууцлал,

хамгаалалтыг хариуцах; 3. Цахим хөгжлийн багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн технологийн аюулгүй байдлын болон халдлагын үеийн арга хэмжээ, бодлого, журам, зааврыг мөрдөх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	- Кибер аюулгүй байдлыг хангах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, стандартын хэрэгжилтийг хангах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах; - Кибер аюулгүй байдлыг хангах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, стандарт, эрсдэлийн талаар удирдлагыг бодит мэдээллээр хангах - Кибер аюулгүй байдал алдагдсан, зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох хүрээнд байгууллагын удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авах; - Кибер аюулгүй байдлын чиглэлээр албан хаагчдад сургалт, мэдээлэл өгөх, гарын авлага, материал бэлтгэх.	Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х Г, Т Г, Х Г
2 дугаар зорилтын хүрээнд	- Байгууллагын кибер аюулгүй байдал, нууцлалын найдвартай ажиллагааг хангах, сайжруулах, хяналт тавих, алдааг илрүүлэх, засварлах; - Байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах, чиглэлээр шинэ дэвшилтэт техник, технологи, программ хангамжийн судалгаа шинжилгээ хийх, шинэ шийдэл боловсруулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх; - Сервер болон бусад тоног төхөөрөмжид кибер халдлагаас хамгаалахад шаардлагатай программуудыг суулгах, тохиргоог хийх; - Сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах, шинээр суулгах, тохиргоог хийх.	Мэдээллийн систем, программ хангамжийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангасан байна	Г, Х Г Г, Х Г, Х

ГАЛЛААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР

ЭХ ХУВЬ 2022 оны 1/17 дугаар

ТУШААЛ

3 дугаар зорилтын хүрээнд	1. Кибер аюулгүй байдлын чиглэлээр шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, стандартыг албан хаагчдад танилцуулах, зааварчилгаа өгөх; 2. Кибер аюулгүй байдлын талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах, тайлагнах; 3. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагын хэмжээнд мөрдөх дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах; 4. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай зэрэг цахим хөгжлийн багц хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд хариуцан зохион байгуулах; 5. Байгууллагын кибер аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, санал, зөвлөмж боловсруулж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	Цахим хөгжлийн багц хуулиудын хэрэгжилтийг хангаж ажилласан, үр дүнг тооцсон байна.	Г, Т Г Г Г, Х Г
Бусад үйл ажиллагаа	1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Архивын тухай хууль, цахим хөгжлийн багц хууль, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" болон бусад эрх зүйн актыг мөрдөж ажиллах; 2. Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх; 3. Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх; 4. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх; 5. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, чиг үүргийн хүрээнд тушаал, албан бичиг боловсруулах, холбогдох	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Г Г Г Г

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР
ЭХ ХУВЬ... ОНЫ... дугаар
ТУШААЛ

	байгууллагад хүргүүлэх;		
	6. Байгууллагатай харилцах үйлчлүүлэгчдэд хариуцсан асуудлаар зөвлөгөө, мэдээллийг үнэн зөв хүргэх;		Г
	7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх;		Г
	8. Хариуцсан ажлын чиглэлээр боловсруулан гаргасан албан бичгийг стандартын дагуу цэгцэлж, байгууллагын архивд хүлээлгэн өгөх;		Г
	9. Аюулгүй арга хэмжээ, хөдөлмөр хамгааллын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тайлагнах;		Г
	10. Өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган холбогдох мэргэжилтэнд өгөх;		Г
	11. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.		Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	- Кибер аюулгүй байдал /061202/; - Программ хангамж /061302/; - Мэдээллийн систем /061303/; - Мэдээллийн технологи /061304/; - Өгөгдлийн сангийн загварчлал, удирдлага /061205/.	
Мэргэшил	Кибер аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн байх	
Туршлага	Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - ажлын чиг үүрэгт хамаарах асуудлаар мэдээлэл цуглуулж дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах чадвартай байх; - бусад
	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа оновчтой хэрэглэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, арга замыг тодорхойлох; - хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; - бусад

ГАЛМАДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР

ЭХ ХУВЬ 2022 оны 1/15 дугаар

ТУШААЛ

	Багаар ажиллах	- мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - бусад
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - компьютерын хэрэглээний программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх; - албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн чадвартай байх; - эрх бүхий байгууллагын төрийн болон албаны нууцын тухай сургалтад хамрагдсан байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

..... Д.МӨНХБААТАР

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

1116126933 2712253

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН

Байгууллагын нэр:

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

22 08 30

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА

..... Н.УУГАНБАЯР

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

